



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/80

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласантай холбогдуулан Авлигатай тэмцэх "Шүүр" ажиллагааны хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын хэмжээнд хүний нөөцийн үйл ажиллагааг шалгаж, хууль, тогтоомж зөрчиж томилогдсон албан тушаалтныг илрүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга:
Ц.Одхүү

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга

Ажлын хэсгийн дэд дарга:
А.Мөнхбат

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

Нарийн бичгийн дарга:
Э.Бадамсүрэн

Төрийн захиргааны удирдлагын газрын хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах шинжээч

Гишүүд:
С.Мяндасмаа

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

П.Насанжаргал

Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн

Д.Оюунсүрэн

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Цэнд

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

Т.Орхонтамир

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

080070205

П.Энхзул	Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
Ш.Мөнхбулган	Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
А.Оюунболд	Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн
У.Мөнхцэцэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах шинжээч
Д.Баярмаа	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч
Л.Шинэчимэг	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч
Б.Гантөмөр	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч
О.Нямхүү	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч
У.Бямбадулам	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн
Э.Солонго	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

2.Ажлын хэсгийн баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Шалгалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хийж гүйцэтгэн, тайлан дүгнэлтийг 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн дотор Зам, тээврийн хөгжлийн Сайдад танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Одхүү)-т даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн
А/80 дугаар тушаалын хавсралт



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН
ТОМИЛГООНД ХИЙХ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**

Нэг. Нийтлэг үндэслэл

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Компанийн тухай хууль, Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг үндэслэл болгон шалгалтыг явуулна.

Хоёр. Шалгалтын зорилго

Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласантай холбогдуулан Авлигатай тэмцэх "Шүүр" ажиллагааны хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын хэмжээнд хүний нөөцийн үйл ажиллагааг шалгаж, хууль, тогтоомж зөрчиж томилогдсон албан тушаалтныг илрүүлж, зерчил, дутагдлыг арилгах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Гурав. Шалгалтын хамрах хүрээ, хугацаа

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний засгийн газрын агентлаг, төсвийн байгууллага, төрийн болон төрийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газруудын хүний нөөцийн үйл ажиллагаанд 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ажлын 6 хоногт багтаан шалгалтыг хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Шалгалтад хамрах асуудал

- Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйл, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, улсын үйлдвэрийн газрын дүрмээр тогтоосон журмын дагуу томилогдсон эсэх;
- Байгууллагын удирдлагын баталсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага хангаагүй албан тушаалтан ажиллаж байгаа эсэх;
- "Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалт"-д хамаарах албан тушаалтнууд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг Авлигатай тэмцэх газарт хянуулж томилогдсон эсэх;
- Холбогдох албан тушаалтнууд "Хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг тогтоосон хугацаанд мэдүүлсэн эсэх;
- Хуулиар тогтоосон хязгаарлалтыг зөрчин томилогдсон, томилох эрх бүхий албан тушаалтны хамаарал бүхий этгээд байгаа эсэх ;
- Авлига, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээд ажиллаж байгаа эсэх;

- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан ёс зүйн хэм хэмжээг удаа дараа зөрчсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон этгээд ажиллаж байгаа эсэх;
 - Нийтийн албан тушаалтны удирдах болон харьяалах, зохицуулалтад шууд хамаарах салбарт түүний хамаарал бүхий этгээд ашиг олох зорилгоор үйл ажиллагаа явуулдаг, энэ байдал нь давуу байдал үүсгэхүйц нөхцөл үүсгэсэн этгээд ажиллаж байгаа эсэхийг тус тус шалган тогтооно.
- **Тав. Үүрэг хариуцлага**

Шалгалтад хамрагдаж буй байгууллага:

- Ажлын хэсэгт шаардлагатай тайлан мэдээ, тушаал, санхүүгийн болон бусад холбогдох материалыг шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгөх;
- Шалгалтын явцад холбогдох программ хангамжид нэвтрэн шалгалт хийх нөхцөл бололцоогоор хангах;
- Шалгалтын тайлангийн төсөлтэй танилцаж санал, тайлбар өгөх;
- Ажлын хэсгээс гарсан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх.

Шалгалт хийх ажлын хэсэг:

- Шалгалтыг удирдамжийн хүрээнд зохион байгуулах;
- Шалгалтын явцад хамрагдаж буй байгууллага, нэгжийн мэдээллийн нууцлалыг хадгалах;
- Шалгалтыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу гүйцэтгэх;
- Шалгалтын тайлангийн төслийг тухайн байгууллагын холбогдох албан тушаалтанд танилцуулах;
- Ажлын хэсэг шалгалтын дүнг нэгтгэн Зам, тээврийн хөгжлийн сайдад танилцуулж, ажлын хэсгээс гарсан шийдвэр, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.

---o0o---

